

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2020/05/СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он	Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд	
	тэргүүлэх аудитор:	Ц.Наранчимэг
	Утас: 261663	Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn
	Аудитын менежер:	Г.Гүнжидмаа
	Утас: 261885	Цахим хаяг: Gunjidmaag@audit.gov.mn
	Аудитор:	Г.Мөнхчимэг
		Утас: 261628
		Цахим хаяг: Munkhchimegg@audit.gov.mn
		Аудитор:
		Ч.Дашдаваа
		Утас: 261628
		Цахим хаяг: Dashdavaach@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	2
2.	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12	Шилэн дансны мэдээлэл	9
2.13	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3.	Менежментийн захидал	11
3.1	Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ААНБ	Аж, ахуйн нэгж байгууллага
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗАХИРАЛ
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

2020.03.25 № 01/948
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирал Б.Батцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлдэгч нартай үүссэн өр авлагыг тухай бүр барагдуулах, худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Засгийн газрын тусгай сан нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 16-наас 3 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ч.Дашдаваа, Г.Мөнхчимэг, гэрээт аудитор Ш.Ичинхорлоо нар хариуцаж хэрэгжүүлэв.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/381 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд тодорхойлон ажиллажээ.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;
- Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбар, чиглэлийн талаар санал боловсруулж, Засгийн газраар шийдвэрлүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авах санал боловсруулж зохих байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрийн талаар шаардлагатай судалгааг тогтмол явуулж, үр дүнг нийтэд мэдээлэх.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үндсэн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн удирдлага ЗГ-ын тусгай сангийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 2019 оны 11 дүгээр сарын 13-нд шинэчилсэн найруулга хийж 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” программ хангамж ашигладаг байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй

нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дүгээр улирлын санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, эрсдэлийн түвшинг их гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.2 хувиар тогтоов.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгийн 0.2 хувиар сонгож 625.9 сая төгрөгөөр тооцсон.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,338.2 сая төгрөгөөр буюу 7.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	291,445.6	311,236.4	19,790.8
Урьдчилгаа	35.7	0.8	(34.9)
Бараа материал	34.7	873.3	838.6
Үндсэн хөрөнгө	94.1	837.8	743.7
Нийт хөрөнгө	291,610.1	312,948.3	21,338.2
Богино хугацаат өр төлбөр	411.9	13,717.9	13,306.0
Урт хугацаат өр төлбөр	123,989.7	54,360.2	(69,629.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	167,208.5	244,870.2	77,661.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	291,610.1	312,948.3	21,338.2

Авлага дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Татаас санхүүжилтийн авлага

- 2019 оны давсан орлогын зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн 303.9 сая төгрөгийг,
- Ажиллагсдын хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 0.5 сая төгрөгийг тус тус татаас санхүүжилтийн авлага дансанд бүртгэсэн.

Байгууллагаас авах авлага

- Шүүхийн шийдвэрийн дагуу 48 зээлдэгчээс авах 0.8 сая төгрөгийн тэмдэгтийн хураамж, 4 аж ахуйн нэгжээс авах 0.9 сая төгрөгийн зээлийн авлагыг,
- Урьдчилж төлсөн сургалтын төлбөрийн 1.6 сая төгрөгийн авлагыг тус тус байгууллагаас авах авлага дансанд бүртгэсэн.

Хувь хүмүүсээс авах авлага

- Мал хамгаалах сангийн балансаас балансад шилжин ирсэн 2.1 сая төгрөгийн үнэтэй цахилгаан саалтуурыг 2 иргэнд зээлээр борлуулж авлагаар,
- Нэр бүхий иргэдээс авах 1.3 сая төгрөгийн авлагыг тус тус хувь хүмүүсээс авах авлага дансанд бүртгэсэн.

Зээлийн авлага

- Тайлант онд 2009-2018 онуудад олгогдсон зээлийн эргэн төлөлт хийгдэж, авлага 77,862.5 сая төгрөгөөр буурсан боловч 2019 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон 44,565.1 сая төгрөгийн зээлийн авлага, Мал хамгаалах сангийн балансаас балансад шилжсэн 32,515.5 сая төгрөгийн зээлийн авлагаар тус тус өссөн,
- Мөн 2008-2019 онуудад олгосон төлөгдөөгүй 6,199.4 сая төгрөгийн зээлийг илрүүлсэн ба хугацаандаа төлөгдөөгүй зээлийн алданги 5,264.0 сая төгрөг, нэмэгдүүлсэн хүү 101.0 сая төгрөгийг тус тус тооцож зээлийн авлага дансанд тайлант онд бүртгэсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай. Үүнд:

Бэлэн бүтээгдэхүүн

- Мал хамгаалах сангаас 233.9 сая төгрөгийн үнэ бүхий ХАА-н тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн авч бэлэн бүтээгдэхүүн дансанд бүртгэсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр 198.0 сая төгрөгийн "Төсөл сонгон шалгаруулах зээлийн нэгдсэн ERP систем" программ худалдан авсан.
- Өөрийн хөрөнгөөр 35.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 9.7 сая төгрөгийн тавилга хэрэгсэл, 35.2 сая төгрөгийн программ хангамж, нийт 80.4 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан.
- Мал хамгаалах сангаас 50.9 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 74.7 сая төгрөгийн агуулахын барилга, 16.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 6.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2,570.2 сая төгрөгийн ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, шүүхийн шийдвэрийн дагуу хураан авсан 88.3 сая төгрөгийн газар /эзэмших эрхийн гэрчилгээ/, нийт 2,807.2 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авснаас тус тус шалтгаалжээ.

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 248.3 сая төгрөгийн акталсан хөрөнгөөр үндсэн хөрөнгийн дүн буурсан байна.

Биет бус хөрөнгө нэмэгдсэн нь Шүүхийн шийдвэрийн дагуу зээлийн төлбөрт 88.3 сая төгрөгийн 2 газар /эзэмших эрхийн гэрчилгээ/-ыг хураан авч бүртгэсэнтэй холбоотой.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх улсын төсвийн зээлийн 17,000.0 сая төгрөгийн өр төлбөрийг балансаас балансад шилжүүлэн авч, тайлант хугацаанд 3,815.9 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан.
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох зээл, төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг цахимжуулах мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлын төсөв 200.0 сая төгрөгөөр батлагдсанаас 2020 онд төлөх 100.0 сая төгрөгийг өглөгөөр бүртгэсэн.
- Зээлийн эргэн төлөлттэй холбоотой нэр тодорхойгүй 42 харилцагчийн 30.3 сая төгрөгийн орлогыг бүртгэсэн.
- Сангийн сайд болон ХХААХҮС нарын 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр 99,561.0 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулах 190412/08-100/35 тоот гэрээ байгуулсан. Уг гэрээний дагуу үүссэн 383.8 сая төгрөгийн алдангийн төлбөр төлөгдөөгүй байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих”-д зориулан Засгийн газрын бондын эх үүсвэрээр 2011-2012 онуудад тус санд 290,100.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн улсын төсөвт буцаан төлөх 99,561.0 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөр байна. Үүнээс тайлант онд 49,513.2 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэн.
- Засгийн газрын 2014 оны 176 дугаар тогтоолын хүрээнд Хөгжлийн банкны эх үүсвэрээр арилжааны 10 банкаар дамжуулан олгосон зээлээс 20,693.2 сая төгрөгийг төвлөрүүлж, үлдэгдэл 3,867.1 сая төгрөгийн өр төлбөр байна.

Тус сан Засгийн газрын бондын эх үүсвэрээс санхүүжүүлсэн зээлийн үлдэгдэл 41,059.1 сая төгрөг, Хөгжлийн банкны эх үүсвэрээс арилжааны банкаар дамжуулан олгогдсон зээлийн үлдэгдэл 3,506.0 сая төгрөг, нийт 44,565.1 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл татан буугдсан капитал банкнаас шалтгаалан хугацаа хэтэрсэн байна.

Бусад 445.2 сая төгрөгийн өр ХХААХҮС, Өмнөговь аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан 190717/01/247 тоот гэрээний дагуу тус аймгийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2,980.0 сая төгрөгийн санхүүжилтийг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд авсан. Үүнээс 445.2 сая төгрөгийн зээл олгогдож, үлдэгдэл 2,534.7 сая төгрөгийг буцааж шилжүүлсэн.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн Капитал банкнаас авах зээлийн авлага буюу Засгийн газрын бондын эх үүсвэрээс санхүүжүүлсэн зээлийн үлдэгдэл 41,059.1 сая төгрөг, Хөгжлийн банкны эх үүсвэрээс арилжааны банкаар дамжуулан олгогдсон зээлийн үлдэгдэл 3,506.0 сая төгрөг, нийт 44,565.1 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл зээлийн авлага дансыг, урт хугацаат өр төлбөр дансыг тус тус нэмэгдүүлж байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 8 арга хэмжээнд зориулан 48,179.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 47,000.0 сая төгрөгийг жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд, 101.5 сая төгрөгийг биет бус хөрөнгийн зардалд, 1,078.4 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 47,101.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,078.4 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос зарцуулахаар баталжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 48,600.6 сая төгрөг буюу 100.9 хувьтай байна. Урсгал үйл ажиллагааны зардал 1,156.4 сая төгрөг буюу 98.0 хувьтай, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас олгох зээлийн гүйцэтгэл 47,444.1 сая төгрөг буюу 100.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл тодорхойлж горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 438.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 232.9 сая төгрөгийн 2 албан шаардлага, 5.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 200.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. Үүнд:

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2009-2013 онд олгосон 32 иргэн, ААНБ-ын он дамжсан зээлийн авлага, 2014-2018 онд олгосон гэрээний хугацаа дуусаагүй боловч зээл, зээлийн хүүгийн төлөлт хийгдээгүй авлагыг тус тус барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 16.5.1 "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Хөгжлийн банкны 888 төслөөс Үндэсний хөрөнгө оруулалтын банкаар дамжуулан олгосон 2019 онд төлбөл зохих 232.9 сая төгрөгийн үндсэн зээл болон зээлийн хүүг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "....., бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Ажилтнуудад олгосон урамшууллаас нийт 5.7 сая төгрөгийн НДШ-ийг суутган тооцоогүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4-д "аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 200.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас авсан зээлийн төлбөрөө гэрээний хугацаандаа төлөөгүй, хууль шүүхийн байгууллагад шилжүүлсэн 72 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын зээлийн эргэн төлөлт,

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2009-2011 он, 2014 онуудад Капитал банк, Хөгжлийн банкт гурвалсан гэрээ байгуулан Засгийн газрын бондын болон Хөгжлийн банкны эх үүсвэрүүдээс олгосон зээлийн төлбөрийн үлдэгдэл 42,901.3 сая төгрөгийн авлагыг Монгол банкин дахь Капитал банкны эрх хүлээн авагчтай тооцоо нийлж, баталгаажуулсан боловч авлагыг барагдуулаагүй байгаа асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 83 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,772.6 сая төгрөгийн зөрчил арилгах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд, зөвлөмжийн хэрэгжилт 73.3 хувьтай байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

2019 оны 06 дугаар сарын 17-нд "Төсөл сонгон шалгаруулах зээлийн нэгдсэн ERP систем" санхүүгийн программыг 200.0 сая төгрөгөөр худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар 8.1.1 заалт "Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Холбогдох эрх зүйн акт зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөн ажиллаж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	291,516,098,241.64	312,110,552,567.12
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.01	8.03
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.01	0.01
31110	Төгрөг	0.01	0.01
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	8.02
31210	Төгрөг	0	8.02
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	0	8.02
33	АВЛАГА	291,445,628,562.63	311,236,425,480.09
33300	Татаас, санхүүжилтийн авлага	15,735,100.11	304,552,578.00
33500	Бусад авлага	291,429,893,462.52	6,853,204.04
33510	Байгууллагаас авах авлага	291,428,543,062.49	3,374,804.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,350,400.03	3,478,400.04
33600	Зээлийн авлага	0	310,925,019,698.05
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	0	310,925,019,698.05
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	0	310,925,019,698.05
34	УРЬДЧИЛГАА	35,720,000.00	810,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	14,600,000.00	810,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	21,120,000.00	0
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	21,120,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	34,749,679.00	873,317,079.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0	233,930,000.00
35400	Хангамжийн материал	34,749,679.00	639,387,079.00
35410	Бичиг хэргийн материал	6,552,050.00	7,754,600.00
35420	Аж ахуйн материал	4,164,970.00	5,569,970.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0	15,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,400,000.00	340,000.00
35450	Барилгын засварын материал	0	270,000.00
35470	Бусад хангамжийн материал	19,632,659.00	625,437,509.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	94,159,478.03	837,838,952.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	94,159,478.03	837,838,952.35
39200	Биет хөрөнгө	58,299,477.87	516,338,952.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	0	74,770,370.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0	-24,860,527.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	124,771,181.00	175,757,081.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-124,771,181.00	-175,757,081.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	71,542,044.19	67,659,254.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-57,991,585.74	-20,730,894.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	78,946,107.20	84,766,137.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,064,587.78	-36,976,879.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,950,000.00	2,575,167,944.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-82,500.00	-2,203,456,452.51
39300	Биет бус хөрөнгө	35,860,000.16	321,500,000.00
39301	Програм хангамж	181,500,000.00	233,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-145,639,999.84	0
39303	Бусад биет бус хөрөнгө	0	88,300,000.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	291,610,257,719.67	312,948,391,519.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	124,401,740,345.71	68,078,225,338.54
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	411,972,986.29	13,717,994,576.33
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0	13,184,047,527.15
41210	Төгрөг	0	13,184,047,527.15
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	0	13,184,047,527.15
41300	Өглөг	383,882,172.29	503,567,331.84
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	340,999.00
41350	Зээлийн хүүгийн өглөг	383,882,172.29	383,882,172.29
41360	Бусад өглөг	0	119,344,160.55
41361	Байгууллагад төлөх өглөг	0	119,079,422.53
